



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 143

Булагтай

Хүдэр сумын Ойн ангийн 2020 оны төсвийг
батлах тухай

Монгол Улсын Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7 дах заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 28 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хүдэр сумын “Ойн анги” ОНӨААТҮГ-ын 2020 оны төсвийг хавсралтаар баталсугай.


2. Ойн ангийн үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн зардал гаргуулахгүй байх, цаашид үйл ажиллагаагаа санхүүжүүлэх эх үүсвэрийг бий болгоход нь дэмжлэг үзүүлж ажиллахыг сумын Засаг дарга /Д.Пүрэвдорж/-д даалгасугай.

3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, хагас бүтэн жилээр сумын ИТХ-д тайлагнах, орлогоо нэмэгдүүлэхэд анхаарч, мод үржүүлгийн газартай болох талаар арга хэмжээ авч ажиллахыг сумын Ойн ангийн дарга /Г.Тайванбаатар/-д даалгасугай.

ДАРГА /Г.Тайванбаатар/ Т.ЭРДЭНЭБАТ



Сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 143 дугаар тогтоолын хавсралт.



ОЙН АНГИ ОНӨААТҮГАЗРЫН 2020 ОНЫ ТӨСӨВ

№	Төрөл	Тоо хэмжээ /мян.төгрөг/	Тайлбар
1	Орлого		
1.1	Үндсэн үйл ажиллагааны орлого /талбай тусгаарлалт /	20,000,000	800га*25000
1.2	Ойжуулалт, нөхөн сэргээлт	2,780,000	20 га *695,000*20%/ашиг/
1.3	Орон нутгийн төсвөөс	0	
1.4	ААНБ, иргэний хандив, тусламж	0	
1.5	Хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад эх үүсвэр	4,980,000	Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.5 дах заалтаар
1.6	Гэрээт ажил	3,500,000	БОАЖЯ, ОСХТөв, БОАЖГ- Ойжуулалт, Арчилгааны огтлолт
	Орлогын нийт дүн	31,260,000	
2	Зарлага		
2.1	Цалин	23,520,000	1,960,000*12сар
2.2	НДШимтгэл /байгууллагаас 12%/	3,175,200	23,520,000*13.5%
	Нийт цалингийн зардал	26,695,200	
2.3	Шатахуун	2,500,000	208,300*12сар
2.4	Томилолт	1,200,000	
2.5	Бичиг хэрэг	864,800	
	Зардлын нийт дүн	31,260,000	

“Ойн анги” ОНӨААТҮГазар